

ДОЛООН НАСТАЙ ХҮҮХДИЙН ТАНИН МЭДЭХҮЙН ОНЦЛОГ

Д.Санжжав, Сэтгэл судлалын ухааны доктор, профессор

“Сургуулийн системийг боловсронгуй болгох тухай” МАХН-ын Төв Хорооны сэдэвт хүүхдийг 7 настайгаас нь элсүүлж сургах тухай заасан билээ. Сүүлийн жилүүдэд манай орны хот хөдөөгийн зарим сургуульд хүүхдийг 7 настайгаас нь I ангид элсүүлж сургаж байгаа туршлага бий.

ЗХУ-ын нэрт сэтгэл зүйч Л.С.Выготский сургалт, хүүхдийн оюун ухааны хөгжлийн харилцан холбооны тухай онолын үндсийг марксист-ленинист сургаалын үүднээс боловсруулж сургалтын агуулга, хэлбэр, арга барилыг хэдий чинээ боловсронгуй болгож чадна, хүүхдийг багаас нь эхлэн төдий чинээ амжилттай сургаж тэдэнд шинжлэл ухааны үндсийг ухамсартай, гүн бат эзэмшүүлж болно гэдгийг тодорхойлсон юм. Л.С.Выготский сургалтын процесс ямагт түрүүлж түүний хойноос хүүхдийн оюун ухаан дагалдан хөгждөг гэж сургалт, оюун ухааны хөгжлийн харилцан холбооны тухай асуудлыг зөв шийдвэрлэсэн байна.

Орчин үеийн шинжлэх ухаан, техникийн үсрэнгүй дэвшил, хүүхэд багачуудын оюун ухаан, ёс суртахууны болон бие махбодын хөгжилд асар их нөлөө үзүүлж байгаагаас хүүхдийн өсөлт хөгжилтийн хурдац нэмэгдлээ.

Хөгжлийн хурдцыг илтгэн харуулах насны нэг үе бол 6-7 нас юм. Ийм учраас орчин үеийн хүүхдийг сурган хүмүүжүүлэх үйл явцыг хөгжлийн энэхүү онцлог зүй тогтолтой нарийн уялдуулж зохион явуулах шаардлага тавигдаж байна. Энэхүү шаардлага нь сургалтын агуулга, хэлбэр, арга барилыг улам бүр төгөлдөржүүлж хүүхдийг багаас нь сургаж, тэдний оюун ухааны хөгжлийн нөөц, чадавхыг бүрэн шавхан дайчилж хүүхэд бүрд шинжлэх ухааны нарийн ухагдахууныг ул суурьтай, гүн бат эзэмшүүлэх бүтээлч үйл ажиллагаагаар хэрэгжих болно.

Хүүхдийг 6-7 настайгаас нь эхлэн сургуульд элсүүлж сургах ажлын физиологи, сэтгэл зүйн онцлог юу болох, энэ насанд хүүхэд оюун санаа, бие бялдрын талаар сургуульд элсэн суралцахад хэрхэн бэлтгэгдсэн байх ёстой вэ? гэдэг асуудлын талаар товч өгүүлье.

Юуны түрүүнд 7 настай хүүхдийн их тархины гадрын бүх давхаргын мэдрэлийн эсүүдийн бүтэц,

тархины үйл ажиллагаа гүйцэтгэх боломж нь насанд хүрсэн хүний их тархины гадрын хөгжлийн бүхий л үзүүлэлтүүдийн хэмжээнд ойртсон байдаг учраас хүүхдийг сургуульд элсүүлэн сургах ажлыг 6-7 наснаас нь эхлэн зохион явуулах боломж бүрэн бүрдсэн гэж орчин үеийн сэтгэл судлал, физиологийн шинжлэх ухаан үзэж байгаа юм. 7 настай хүүхдийн тархины жин насанд хүрсэн хүний тархины жингийн 90 хувьд хүрсэн байдаг. Түүнчлэн 7 настай хүүхдийн тархины духны хэсгийн (их тархины гадрын духны зүүн хэсэгт хүний үг яриа, сэтгэхүйн төв байрласан байна) болон дагзны (энэ хэсгийн эсийн талбайд харааны төв байрласан байна) хэсгийн мэдрэлийн эсийн талбайн хөгжил насанд хүрсэн хүнийхтэй ойролцоо төвшинд хөгжсөн байдаг байна. 7 настай хүүхдийн их тархины гадрын талбайн олон хэсэг ба мэдрэлийн янз бүрийн төвийн хооронд холбоо тогтоох эвсэл холбоосны ширхгүүд эрчимтэй хөгжсөн байдаг.

6-7 насны үеэс эхлэн хүүхдийн их тархины гадрын баруун, зүүн тал бөмбөлгийн хооронд тэгш биш байдал үлэмж түргэн хөгжиж тэдгээр бөмбөлгүүд нь тус бүрдээ харилцан өөр өөр үүрэг гүйцэтгэх хөгжлийн төвшин нь насанд хүрсэн хүний тархины хөгжлийн төвшинд хүрнэ. Ингэж 6-7 наснаас эхлэн хүүхдийн их тархины 2 тал бөмбөлгийн үйл ажиллагаа тэгш биш үүрэг, гүйцэтгэж байгаа нь энэ насны хүүхдийг системтэй сургалтад хамруулж тэдэнд мэдлэг эзэмшүүлэх физиологийн нөхцөл бололцоо хангагдсан байдлыг нотолж байгаа юм. 7 насны үед хүүхдийн их тархинд явагддаг саатлын процесс хүчтэй хөгжиж байдаг тул тэр нь хүүхдийн зан төлөв, биеэ авч яваа байдлыг зохицуулахад сайн нөлөө үзүүлдэг байна. 7 настай хүүхдийн бие махбодын болон уураг тархины бүтэц, тархины үйл ажиллагаа, гүйцэтгэх боломжуудад гарч байгаа өөрчлөлтүүд нь тэдний сэрэл, хүртэхүй, ой тогтоолт анхаарал сэтгэхүй, хэл яриа, дүрслэн бодох зэрэг сэтгэцийн бүх процессуудын хөгжилд нөлөөлж тэдний танин мэдэх үйл ажиллагааг хөгжүүлэх физиологи, сэтгэл зүйн тааламжтай нөхцөлийг бий болгож байгаа юм. Юуны түрүүнд хүүхдийн танин мэдэхүйн анхны

шат болох сэрэл, хүртэхүйн хөгжилд чанарын шинэ шинэ өөрчлөлтүүд гарсан байдаг. Жишээ нь, 6-7 насны үед хүүхдийн их тархины гадрын хараа, хөдөлгөөний төвийн хооронд мэдрэлийн түр зуурын нарийн холбоос бүрэлдэн тогтсон байдаг учраас тэд бичих, зурах дасгал ажиллагаа идэвхтэй гүйцэтгэх боломжтой болсон байдаг.

Энэ насны хүүхдийн оюун ухааны ерөнхий хөгжлийн зэрэгцээгээр тэдний мэдрэхүйн эрхтнүүдийн анализаторуудын (задлан ялгагчдын) аппаратын бүтэц, үйл ажиллагаа улам нарийсан хөгжсөн байдаг учраас гаднаас нөлөөлөх үнэр, амт, дуу чимээ, хөдөлгөөн зэрэг юмс үзэгдлүүдийн шинж чанарыг хүлээн авч тэдгээрийг ялган таних чадвар нь эрс сайжирна. Тэрчлэн мэдрэхүйн эрхтний олон анализаторын хооронд үлэмж нарийн холбоос тогтсон байдаг тул юмс үзэгдлүүдийн шинж чанарыг нэгэн бүхэл цогцолбор болгон тусгах чадвар дээшилсэн байна. Үүний үр дүнд I ангид ороод багшийн ярьж тайлбарлаж байгаа зүйлийн агуулгыг нэгтгэн тусгаж өөртөө мэдлэгийн ямар нэгэн нэгдмэл холбоосыг бүрдүүлж чаддаг болдог.

7 настай хүүхдийн танин мэдэх процессын бас нэг онцлог хөгжил гэвэл тэд хол ойр, баруун зүүн, дээр дор, урт богино, гурвалжин дөрвөлжин, их бага гэх мэтээр юмсын оршин байгаа орон зайн харьцаа, өнөө маргааш, эрт, орой, удаан түргэн гэх мэт юмсын дүрс хэлбэр, байрлал, цаг хугацаа, хөдөлгөөнийг тусгасан хүртэхүй нарийн хөгжсөн байдаг явдал юм. 7 настай хүүхдийн төв мэдрэлийн системд явагдах мэдрэлийн процессуудын төвлөрөлт, тогтворжилт, саатлын процесс сайжирч байдаг учраас тэдний анхаарлын хүч зарчим дээшилж, тодорхой зүйл дээр төвлөрүүлж тогтворжуулах чадвар сайжирдаг. 7 настай хүүхдийн ой, тогтоолтын хөгжилт улам сайжирч тогтоох багтаамжийн хүрээ тэлж, тогтоосон зүйлийг бүрэн гүйцэд, нарийн систем дэс дараатай сэргээн санах чадвар нь өндөр төвшинд хөгжсөн байна. Тэрчлэн юмыг түүний утгын холбоос дээр түшиглэн тогтоон, тогтоосон зүйлээ ой ухаандаа ямагт удаан хугацаанд үлдээн хадгалж чадна. Энэ насанд хүүхдийн ойн хөгжилт санамсаргүй шинжээс санамсартай, зориудын идэвхтэй шинж чанартай болж тогтоох үр ашигтай арга барилыг сонгож авч чадна. 7 настай хүүхдийн хэл, сэтгэхүйн хөгжилд бас чанарын өөрчлөлт гардаг. Бодит, тодорхой сэтгэхүйн үндсэн дээр өөрөөр хэлбэл практик үйлдэл хийх замаар юмсын харьцаа, холбоог ухаарч ойлгох идэвхтэй үйл хийх ба юмс үзэгдлийг танин мэдэхдээ жишиж харьцуулах, тодруулан сэтгэх, ангилах зэрэг сэтгэхүйн үйлдэл хийж чадна. Гэхдээ энэ насны хүүхдийн

сэтгэхүйд юмыг биетэй, бодитойгоор нь үзэж харж, сонсож, хүрэлцэж мэдрэх үйл илүү хөгжсөн байдгийг мартаж болохгүй. Өөрөөр хэлбэл бодит, тодорхой сэтгэхүйн эхний шат болох бодит зүйл дээр тулгуурлаж үйлдэл хийж сэтгэх замаар юмс үзэгдлийн тухай үндсэн ойлголтыг авч чаддаг гэсэн үг. Системтэй сургалтын явцад хүүхэд аажмаар бодит зүйл дээр үйлдэл хийж, урьд өмнө тохиолдож байсан юмсын бодит, тодорхой дүр дээр тулгуурлаж дүрслэн сэтгэх үйл ажиллагаа нь идэвхжинэ. Энэ нь хүүхдийн хийсвэр сэтгэхүйд хөгжихийн угтвар үе болно. 7 насны үед хүүхдийн хэл ярианы хөгжилд үндсэн өөрчлөлт гарч дотоод бодол санаагаа гадагш чөлөөтэй илэрхийлж төрөлх хэлний хэлзүйн хууль дүрмийг эзэмшсэн, үгийн нөөц баялаг нэмэгдэж, үзэж сонссон зүйлийнхээ гол утга санааг товч тодорхой, ойлгомжтой хэлбэрээр бусдад дамжуулж чадна. Түүнчлэн өгүүлэх эрхтний анатоми-физиологийн бүтэц болон үг ярих, өгүүлэх, механизм нь том хүнийхтэй ойролцоо төвшинд хөгжсөн байдаг юм.

Танин мэдэх процессын эдгээр онцлогууд нь тэднийг 7 наснаас эхлэн сургуульд элсүүлж суралцуулах физиологи, сэтгэл зүйн бүхий л боломжууд аль эрт бүрэлдсэнийг (бусад оронд 6 наснаас эхлэн сургаж байгаа) харуулах үзүүлэлт юм. Дээр дурдсан зүйлээс дүгнэлт хийхэд 7 настай хүүхдийг сургуульд элсүүлэн суралцуулах нь дараах үндсэн үзүүлэлтээр тодорхойлогдож байгаа юм.

Долоон настай хүүхэд мэдлэгийн тодорхой нөөцтэй болж хүрээлэн байгаа орчны тухай хүүхдийн төсөөллийн хүрээ өргөсөж, тэдний мэдэх төсөөлөх зүйлийн тоо хэмжээ ихэссэн байдаг нь цаашид тэд сургуульд орж шинжлэх ухааны үндсийг системтэй эзэмших урьдчилсан нөхцөл юм. Мөн хүмүүсийн ёс суртахууны шинж чанар, нийгэмд биеэ авч явах дэг журмын тухай үндсэн төсөөлөлтэй болсон байна.

Цэцэрлэг, гэр бүлийн системтэй зөв зохиогдсон сургалт, хүмүүжлийн ажлын нөлөөгөөр 7 настай хүүхэд янз бүрийн үйлдлийг тухайлбал, хөдөлгөөний болон хөдөлмөрийн энгийн үйлдэл, гүйцэтгэх чадвар дадалтай болсон байна. Мөн оюун ухааны болон практик үйлдэл хийх арга барилд сурсан байна. Энэ үед хүүхэд өөрийн сэтгэхүйн үйлийг жолоодож юмыг зориуд чиг зорилготой тогтоох, сэргээн санах, цээжлэх, анхаарлаа зориуд төвлөрүүлэх чадвар эзэмшдэг. Зарим тохиолдолд өөрийн хүсэл бодлоо барьж саатуулах, биеэ эзэмдэж шаардлагад захирагдаж чадна.

Орчныг танин мэдэх харьцаа төлөвшиж, орчноосоо үзүүлж байгаа үйлдэлтэй өөрийгөө зохицуулах чадвар дадалтай болсон байхаас гадна юмыг жишиж харьцуулах, хүний сайн сайхан зүйлийг ойлгож дуурайх эрмэлзэл илүү хөгжсөн байна. Энэ бүхэн нь 7 настай хүүхдийн танин мэдэх үйлийг тодорхой чиг зорилготой, системтэй болгоно.

Гэхдээ 7 настай хүүхдийн сургалт, хүмүүжлийн ажлыг зохион явуулахад дараах 2 онцлогийг нарийн анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Энэ насанд хүүхдийн тархины бүтцийн ба биеийн өсөлт хөгжилт харьцангуй жигд биш явагддаг. Адилхан насны боловч хөгжлийн хувийн онцлог, амьдралын өвөрмөц нөхцөлөөс шалтгаалж зарим хүүхдийн ерөнхий хөгжил түрүүлэх, эсвэл хожуу явагдаж бодохыг анхаарч, хүүхэд бүрд нэг янзаар хандаж болохгүйг санаж ажиллах.

2. Энэ нас бол хүүхдийн тархины идэвхтэй чанарт түргэн өөрчлөлт гарч байдаг. Ийм учраас хүүхдийн зан төлөв, биеэ авч яваа байдалд нэг талаас ухамсаргүй зан үйлийн, нөгөө талаар зориудын ухамсартай зан үйлийн элемент аажмаар идэвхтэй бүрэлдэн тогтож, байдаг онцлогтой заагийн үе байдаг. Энэхүү онцлог байдлыг сургалт хүмүүжлийн ажилд нарийн харгалзах шаардлагатайг мартаж болохгүй.

Үүний улмаас 7 настай хүүхдийг амжилттай сургахын тулд олон зүйлийг анхаарах шаардлагатай болж байна. Юуны түрүүнд хүүхдийн биеийн эрүүл мэндийг хамгаалж цаашид амжилттай сурахад тэдний бие организмын хэвийн хөгжилтийг хангах нөхцөлүүдийг сургууль, гэр бүлд буй болгоход онцгой анхаарах үүрэгтэй. Ялангуяа сургуульд орсон анхны өдрөөс эхлэн хүүхдийн, өдрийн дэглэмийг нарийн зохион байгуулж, цэвэр агаарт идэвхтэй хөдөлгөөнд байлгах, хичээлийн үргэлжлэх хугацааг 35 минутаар тогтоож хүүхдийг аль болохоор чилээж ядраахаас болгоомжлох, хичээл болон хичээлийн бус цагаар сурах үйл ажиллагааг гүйцэтгүүлэхэд гар хурууны хөдөлгөөн, гимнастик хийлгэх, богино хугацаагаар байгалийн аялал хийх, эхний үед хичээл дээр сургах тоглоомын элементүүдийг өргөн ашиглах, хичээлийн завсарлагыг зөв зохион байгуулж хөдөлгөөний авхаалж самбаа, хурдыг хөгжүүлэхэд зориулж дулаан үед гадаа тоглуулах, тэдний нас биеийн хөгжлийн онцлогт тохирсон спортын болон хөдөлгөөнт тоглоом тоглуулах зэргээр бие махбод, мэдрэлийн системийн хэвийн хөгжлийг хангахад онцгой анхаарах нь чухал юм.

Бас нэг анхаарах зүйл болсон хүүхдийг сургуулийн шинэ нөхцөл байдалд түргэн дасан

зохицох тааламжтай нөхцөлийг буй болгож, сурах сэтгэл зүйн зөв уур амьсгалыг бүхий л талаар бүрэлдүүлэхэд сургууль багш нарын анхаарал төвлөрөх ёстой. Ийм тааламжтай нөхцөл нь юуны түрүүнд хичээлийн эхний үеэс эхлэн хүүхдийн оюун ухааны болон биеийн хүчний ачааллыг зөв зохицуулж, сэтгэл мэдрэлийн аливаа хямрал зөрчилд оруулахаас урьдчилан сэргийлэх явдал юм. Ялангуяа хүүхдийг их хэмжээний мэдээллээр “залхаах” эсвэл сэтгэл санаа, оюун ухааныг нь уйтгартай нэг хэвийн байдалд байлгах явдлаас ямагт сэргийлж, заах зүйлийн агуулгын багтаамж, хүнд хөнгөнийг зөв тохируулах, сургах арга барилыг энэ насны хүүхдийн хөгжлийн онцлог зүй тогтол, оюун сэтгэхүйн нөөц боломжид зохицуулах, эерэг сэтгэхүйн сэтгэлийн хөдөлгөөн, сониуч зан байдлыг хөгжүүлж цаашид идэвхтэй суралцах сэдэл тэмүүллийг нь аажмаар ундруулан хөгжүүлэхэд онцгой анхаарах нь чухал бөгөөд хичээлд сургах тоглоомын элементийг идэвхтэй ашиглах үлгэр домог ярьж өгөх, дуу шүлэг тогтоолгох зэргээр хэл яриа, уран зөгнөл, дүрслэх болон хийсвэр сэтгэхүйг хөгжүүлэх хэрэгтэй.

Сурган хүмүүжүүлэгч. № 3/1987